

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2022 оны 08 сарын 30-ний өдөр

Дугаар 28/2022

Дархан сум

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Хэнтий аймгийн Дархан сумын 4-р баг "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар"-ын ажилд Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын шийдвэрээр байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комисс 2022 оны 08 дугаар сарын 31-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар"-ын ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: .....
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр, дугаар: ТГ-21/07
- 2.3. Захиалагч:  
"Хэнтий аймгийн Дархан сумын ЗДТГ" оноосон нэр,  
Хаяг: Хэнтий аймгийн Дархан сум 4-р баг ЗДТГазар,  
холбоо барих утас: 98830310
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч:  
"Хажуу-Ус" ХХК оноосон нэр, 9011820737 Улсын бүртгэлийн гэрчилгээний  
дугаар, 3617459 регистерийн дугаар, БУ53-464/19 барилгын ажил  
гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар.  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннүгийн гудамж,  
Трю-эл хотхон 719 байр 202 тоот, 95273399, 89554545 холбоо барих утас,  
[Khajuu.us11@gmail.com](mailto:Khajuu.us11@gmail.com) цахим хаяг.
- 2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:  
"Төгс гранд констракшн" ХХК оноосон нэр, 9011606113 Улсын бүртгэлийн  
гэрчилгээний дугаар, 6063721 регистерийн дугаар, ЗТ17-114/21 зураг  
төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин Ван  
Чэгдаржавын гудамж-27, Махаяна 2-р байр, 4-1 тоот, 99041663, 70000338  
холбоо барих утас, [tugsggrandconstruction@gmail.com](mailto:tugsggrandconstruction@gmail.com) цахим хаяг
- 2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:  
"Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургууль" оноосон  
нэр, 9076093 улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар.

Хаяг: Хэнтий аймгийн Дархан сум 4-р баг, Ерөнхий боловсролын сургууль /өөрийн байр/ 98917686 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү Хэнтий аймгийн Дархан сумын 4-р баг "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар"-ын ажилд түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү засварын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

- б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
  - в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.
- 3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 1 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

- 4.1. Хэнтий аймгийн Дархан сумын "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар"-ын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Хэнтий аймгийн Дархан сумын 4-р баг "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авч Хэнтий аймгийн Дархан сумын ЕБС-д шилжүүлэв.

Комиссын дарга:  
Хэнтий аймгийн ГХБХБГ-ын БХБ-ын  
хэлтсийн ахлах инженер



/Б.Гантөгс/

Нарийн бичиг:  
"Хажуу-Ус" ХХК-ийн захирал



/О.Мядаг/

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.